

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР
ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭНД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2023 оны хагас жилийн байдлаар/**

2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Монгол улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилго, зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам Монгол Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 56 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан нийт 2 зорилгын 21 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үнэлгээг 2023 оны хагас жилийн байдлаар Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн /unelgee.gov.mn/ цахим системд байршуулсан 2 зорилтын 21 арга хэмжээний хүрээнд хийлээ.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилгоор нь авч үзвэл:

- МУХТ 2.4.Аж үйлдвэржилтийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд уул уурхайн түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлнэ.
- МУХТ 4.1.Ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглаж, хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хяналтад авагдсан 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан ба биелэлт 59.05 хувьтай /хүснэгт №1/ үнэлэгдлээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн
2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний үнэлгээний товчоо
/2023 оны хагас жилийн байдлаар/

Хүснэгт №1

Хэрэгжилт гаргах нийт төсөл, арга хэмжээний тоо		21
Үр дүнтэй	100%	-
Тодорхой үр дүнд хүрсэн	90%	<u>4</u>
	70%	<u>8</u>
Эрчимжүүлэх шаардлагатай	50%	<u>4</u>
	30%	<u>4</u>
Үр дүнгүй	0%	<u>1</u>
Хугацаа болоогүй	Хугацаа болоогүй	-
Хэрэгжилтийн дундаж		59.05%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн
2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт
/2023 оны хагас жилийн байдлаар/

Хүснэгт 2

Зорилго	Арга хэмжээни и тоо	Үнэлгээ (хувь)						Хэрэгжилт (хувь)
		100	90	70	50	30	0	
2.4. Аж үйлдвэржилтийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд уул уурхайн түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлнэ.	19		4	7	3	4	1	58.9%
4.1. Ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглаж, хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	2			1	1			60.0%
Нийт дүн	21		4	8	4	4	1	59.05%

2023 оны хагас жилийн байдлаар хэрэгжилт хангалтгүй 8 арга хэмжээ байна. Үүнд:

1. Газрын тос дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын ажлын явц, 50%
2. "Алтанширээт аж үйлдвэрийн парк"-ийн барилгын явц, 30%
3. Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах барилгын явц, 30%
4. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлын явц, 50%
5. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр барих ажлын явц, 50%
6. Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх (Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмж нэвтрүүлэх ажлын явц) 30%
7. Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх (Конвейерийн систем нэвтрүүлэх ажлын явц) 30%
8. Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх 50%

2023 оны хагас жилийн байдлаар "үр дүнгүй"-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй 1 арга хэмжээ байна. Үүнд:

1. 2.4.5.2. Геологийн зураглал, судалгааны ажлыг эрчимжүүлэн, гео мэдээллийн нэгдсэн санг баяжуулж, үйлчилгээг цахимжуулах (Геологийн 1:25000-ны масштабын зураглал бүхий газар нутгийн хэмжээ, хувиар) 0 оноо.

Дөрөв. Дүгнэлт

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2023 оны хагас жилийн байдлаар 59.05 хувьтай үнэлэгдэв.
2. 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүд нь ЗГҮАХ-т батлагсан арга хэмжээнүүдээс хэрэгжих хугацаа хоцролттой байна.
3. Хэрэгжилт хангалтгүй, үр дүнгүй арга хэмжээнүүд нь тухайн жилд зарцуулсан хөрөнгө, гүйцэтгэл, санхүүжилт тодорхойгүй, хийсэн ажил авч хэрэгжүүлсэн ажлуудын цаг хугацаа тодорхой бус байгаа нь биелэлтийн түвшинг үнэлэх, бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах тодорхой санал боловсруулахад хүндрэл үүсгэж байна.

Тав. Санал, зөвлөмж

1. Хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, тооцоо судалгаа, дүн шинжилгээний үндсэн дээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилт хангалтгүй болон тасарсан арга хэмжээний талаар холбогдох арга хэмжээг авах,
2. Хэрэгжилт хангалтгүй “үр дүнгүй”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй арга хэмжээг хэрэгжүүлэх, эрчимжүүлэх талаар хариуцсан нэгжүүд онцгой анхаарч тусгайлан төлөвлөгөө гарган хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах, хэрэгжих боломжгүй бол бодлогын баримт бичгээс хасуулах санал бэлтгэх,
3. Төсөл, арга хэмжээг хариуцсан нэгжүүд нь төсөвт өртөг, гүйцэтгэл, санхүүжилтийн хэмжээг нарийн тодорхой тайлагнах,
4. Нэгжүүд Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, арга хэмжээ нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилт, хүрэх үр дүн, хэрэгжих хугацаа болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ, зорилго, зорилт, хүрэх түвшин хэрэгжих хугацаатай хэрхэн уялдаж байгааг анхаарах,
5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн тухайн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авах үйл ажиллагааг холбогдох нэгж, албан тушаалтан хариуцан зохион байгуулах,
6. 2022 онд хэрэгжих байсан арга хэмжээнүүд 2023 онд хэрэгжиж эхэлж байгаа цаашид анхаарч ажиллах.

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга

ХШҮ хийж, танилцуулга боловсруулсан:
ХШҮДАГ-ын ЦБМТХ-ийн шинжээч

Т.Баасанпүрэв

Д.Батнайрамдал

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ
/2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР/**

1	№	Зорилт /бодлогын үндэслэл/	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2023 онд шаардлагатай хөрөнгө		Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
					Суурь түвшин /2021	Зорилтот түвшин /2023/	Хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Эх үүсвэр		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Зорилго 2.4. Аж үйлдвэржилтийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд уул уурхайн түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлнэ.										
1	2.4.1	МУХТЖҮЧ- 4.2.11, ЗГҮАХ- 3.2.7, 3.2.8	Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг түүхий эдийг боловсруулах хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэх	Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар	50	90	200,000.0	Гадаадын зээл, тусламж	ЕРС-01 багц ажлын хүрээнд 2023 оны барилга угсралтын ажлыг 3-р сард эхлүүлсэн бөгөөд төслийн талбайд 647 хүн ажиллаж байна. Иргэний барилгуудын дотор агаар сэлгэлтийн хоолойн угсралт, дотор ханын өрлөг, каркас угсралт, гадна болон дотор шавардлага, гадна дотор цахилгааны ажлууд үргэлжилж байгаа ба зарим барилгуудын дотор заслын ажлууд эхлээд байгаа ба төслийн барилга угсралтын ажлын явц 83%-тай үргэлжилж байна. ЕРС-02 болон ЕРС-03 багц ажлын Ерөнхий гүйцэтгэгчээр шалгарсан Megha Engineering and Infrastructures Limited компани, төслийн менежментийн зөвлөх, МГТБҮ ТӨХХК компанийн инженерүүдийн ролцоотойгоор архитектурын даалгаврыг	70

<p>БХБЯ-аар, Үйлдвэрийн ерөнхий төлөвлөгөөг УУХҮЯ болон Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар болон Онцгой байдлын газраар тус тус батлуулсан. ЕРС-04 багц ажлын Ерөнхий гүйцэтгэлийг сонгон шалгаруулах тендерийн үнийн саналыг 2023.03.29-нд нээж, техникийн болон санхүүгийн үнэлгээг хийж дуусгасан. Тус тендэрт техникийн шаардлага болон үнийн хамгийн бага саналаар Megha Engineering and Infrastructures Limited компанийг шалгаруулаад байгаа ба тус компанитай тендэрт санал болгосон үнийн саналыг бууруулах хэлэлцээр болон гэрээний төсөл дээр ажиллаж байна. Мөн ЕРС-04 багцын гидрокекинг, дизелийн гидроцэвэрлэгээ, бензин үйлдвэрлэх байгууламжийн зураг төсөлд UOR компаниас ирүүлсэн зарим өөрчлөлтүүдийг хянаж байна.</p>	<p>Кемпүүдийн барилга угсралтын ажил -48%, түр замын ажил - 28%, байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -100%, геотехникийн судалгааны ажил -95%, Техникийн зураг төслийн ажил - 90%, Худалдан авалт - 6.08% явагдаж байна. БОННУ хийх ажил 100% БОАЖЯ-д хянагдаж байна. Дамжуулах хоолойн архитектур төлөвлөлтийн даалгаврын</p>
	<p>Гадаадын хөрөнгө оруулалт</p>
	<p>330,000.0</p>
	<p>90</p>
	<p>10</p>
<p>Газрын тос дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар</p>	
<p>2</p>	<p>50</p>

								хүсэлтээ БХБЯ-д хүргүүлсэн. Төслийн ерөнхий гүйцэтгэл: Инженерчлэл - 51%, Барилга угсралт - 7%, Худалдан авалт - 6.08%	
3			"Алтанширээт аж үйлдвэрийн парк"-ийн барилгын явц, хувиар	-	75	912,000.0	Дотоодын хөрөнгө оруулалт	<p>"Инфинити спэйс" ХХК ("Болдтөмөр Ерөө гол" ХХК) өөрийн санхүүжилтээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт нийт 140 га талбайд "Алтанширээт үйлдвэрлэл, технологийн парк" байгуулах төслийг 2019-2025 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Цогцолборын хэмжээнд нийт 420 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалтаар жилд 500 мянган тонн хүчин чадалтай ширэмний үйлдвэр бүхий 5 үйлдвэр байгуулагдах ба эхний 4 үйлдвэр нь ширэмний үйлдвэрээ түүхий эдээр хангах зорилготой.</p> <p>Төслийн явц:</p> <p>2019-2022 онд хийгдсэн ажил:</p> <ul style="list-style-type: none"> • 110/10 кВт-ын 9.4 км цахилгаан дамжуулах агаарын шугам • 6.3 МВт-ын цахилгааны дэд станц • 12 км төмөр зам • Төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр, нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. • Төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэрийг барьж байгуулсан. <p>2023 онд хийгдэж байгаа ажил:</p> <ul style="list-style-type: none"> • Коксын үйлдвэр, төмрийн хүдрийн хорголжийн үйлдвэр, 	30

								<p>ширэмний үйлдвэрийн ТЭЗҮ мөн Паркийн хөгжлийн төлөвлөгөөг тус тус боловсруулж "Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөл"-ийн 2023.06.02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.</p> <ul style="list-style-type: none"> • Мөн үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах бэлтгэл ажлын хүрээнд технологийн түвшний үнэлгээ боловсруулсан ба холбогдох зөвлөлөөр хэлэлцүүлэхээр ажиллаж байна. • НБҮ-ийн барилгын ажил, тоног төхөөрөмж суурилуулах ажлыг 2023.04 сараас үргэлжлүүлэн энэ онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. • Коксын үйлдвэрийн газар, шороо, суурийн ажлыг эхлүүлсэн. (Бүтээн байгуулалтын ажлыг 2023 онд 60%-д хүргэх төлөвлөгөөтэй) 	
4			Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах барилгын явц, хувиар	-	45.4	656,177.5	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	<p>"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК нь "Монгол ган цогцолбор I" төслийг 2022 оноос хэрэгжүүлж байгаа ба төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг батлуулсан. Мөн төсөлд шаардлагатай нэмэлт 77.7 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай Засгийн газрын тогтоол гаргуулсан.</p>	30

								<p>Тус компани нь 2023 оны бизнес төлөвлөгөөг "Эрдэнэс Монгол" ХХК-иар, худалдан авалтын төлөвлөгөөг Сангийн ямаар 2023 оны 4 дүгээр сард тус тус батлуулсан.</p> <p>Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Байгаль орчны үнзлгээ, Төмөртэйн ордын гидрогеологийн судалгаа, төмрийн хүдрийн лабораторийн болон хагас үйлдвэрлэлийн туршилт хийлгэх зэрэг судалгааны ажлуудыг энэ онд хийлгэх, заримыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж сонгон шалгаруулалтуудыг зарлаж эхлээд байна. (Төслийн БОННУ хийлгэх ажлын сонгон шалгаруулалтыг 2023.05.18 зарласан ба 2023.06.19-нд нээнэ.)</p> <p>Төслийн талбайн газар шорооны тэгшилгээний ажлын бэлтгэлийг хангах ажлын төлөвлөгөө батлуулан, талбай чөлөөлөх ажлыг эхлүүлсэн ба энэ ондоо багтааж талбайн газар шороо, тэгшилгээний ажлыг эхлүүлэхээр төлөвлөөд байна.</p>	
5			"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэл хийх барилгын ажлын явц, хувиар	69.4	100	139,020.4	Дотоодын хөрөнгө оруулалт	<p>Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 45%, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 85%, баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 100%-д тус тус хүрсэн. Засварын механикийн заводын ТЭЗҮ-г ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж хүлээн авсан. Ажлын гүйцэтгэл 9%-тай байна.</p>	70

									"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэл 83%-тай байна.	
6			"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" барих ажлын явц, хувиар	-	100	133,663.0	Дотоодын хөрөнгө оруулалт	Үйлдвэр технологийн паркийн (ҮТП) авто зам, төмөр зам, ус хангамж, ариутгах татуургын системийн зураг төсөл, төсвийг 100% гүйцэтгэж, Барилгын хөгжлийн төвөөр батлуулсан. Цахилгаан хангамжийн ТЭЗҮ-ийг 100% гүйцэтгэж, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан. Батлагдсан зураг төсөл хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу дэд бүтцийг барьж байгуулах ажлын тендер шалгаруулалтыг явуулж, зарим ажлууд эхлээд байна. Үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтэц барьж байгуулах ажлын хүрээнд: - Автозам барьж байгуулах ажлын Автозамын гэрэлтүүлэг барьж байгуулах багц-2 тендерт Орхон тех ХХК шалгарч, 2023.03.07-ны өдөр 7/004-23 тоот гэрээг байгуулсан. Гэрээний хугацаа 2024.11.01-нд дуусна. Багц-1 буюу Автозам барьж байгуулах ажлын тендерт шалгарсан Шилдэг зам ХХК болон Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ хооронд 2023.03.14-ний өдөр гэрээ байгуулсан (30% буюу 839.6 сая төгрөгийн санхүүжилтийг	70	

									<p>гүйцэтгэгчид шилжүүлсэн), гэрээний хугацаа 2024.11.01-нд дуусна. Ажил эхлэх зөвшөөрөл болон түр хотхоны зөвшөөрөл авсан, газар шорооны ажил эхэлсэн. Хэвийн үргэлжилж байна.</p> <p>- Төмөр зам барьж байгуулах ажлын тендерт шалгарсан "Туулын гүүр далай" ХХК болон Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ хооронд ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан, гэрээний хугацаа 2023.12.31-ний өдөр дуусна. Газар шорооны ажил 2023.04.09-өөс эхэлж өнөөдрийн байдлаар талбайд 38 хүн, 40 техник хэрэгсэл 24 цагаар ажиллаж байна. Төмөр замын дэр бетон ажлын талбайд бууж байна.</p> <p>- Ус хангамж, ариутгах татуургийн системийг барьж байгуулах ажлын тендер хүчингүй болсон. Дахин тендер зарлахаар ажиллаж байна.</p> <p>- Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах ажлыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Зураг төслийн хүрээлэн гүйцэтгэхээр болж, төсвийг батлуулан "ЭҮ" ТӨҮГ-ын Ерөнхий инженерийн 2023.02.09-ний өдрийн шийдвэрээр нарийвчилсан зураг төслийг 2023.07.31-ний дотор хийж дуусгахыг Зураг төслийн хүрээлэнд даалгасан. "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" Засгийн газрын 2022 оны 171 дүгээр тогтоолын дагуу Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--

									<p>сумдын нутаг дэвсгэрт Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк барих зориулалтаар 1217.4 га газар ашиглах 2022/185 дугаартай гурвалсан гэрээг УУХҮЯ, ГЗБГЗЗГ, Орхон аймгийн Засаг дарга нар 2022.10.25-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу 2022.11.14-ний өдөр №000000019 дугаартай газрын гэрчилгээг УУХҮЯ-ны нэр дээр аваад байна. Үйлдвэрлэл, технологийн паркийн газрын эзэмших, ашиглах газрын хил заагийн эргэлтийн цэгийг тэмдэгжүүлж, солбилцол тодорхойлох, шалгах ажил хийгдсэн, паркийн газрын 1:500 масштабтай байрзүйн дэвсгэр зургийг боловсруулсан.</p> <p>-Паркийн хашаа барих: ажлын тендерт шалгарсан "Орчлонтулга" ХХК-тай 2022.12.05-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ ЭҮ ТӨҮГ байгуулсан бөгөөд нийт 18 км хашаа барихаас 8 км-ийг бариад байна.</p> <p>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах уул уурхай, металлурги химийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн ТЗЗҮ болон паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажилд 1590 сая, паркийн техник, технологийн түвшний үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний ажилд 450.9 сая, үйлдвэрлэл, технологийн паркийн нутаг дэвсгэрийн геоэкологи, гидрогеологийн</p>
--	--	--	--	--	--	--	--	--	---

									<p>суурь судалгааны ажилд 265.3 сая, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх ажилд 101.8 сая, автозамын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажилд 72.6 сая, төмөр замын нарийвчилсан зураг төсөл боловсруулахад 214.9 сая, ус хангамж, ариутгах татуургын нарийвчилсан зураг төсөл боловсруулахад 590.8 сая, цахилгаан хангамжийн ТЭЗҮ боловсруулахад 68 сая, диспетчерийн үндэсний төвөөр горимын тооцоо хийлгэхэд 29.7 сая, 3 ширхэг дэд станцын техникийн нөхцөл гаргуулах төлбөрт 4.5 сая, ҮТП-ийн автозам болон автозамын гэрэлтүүлэг барьж байгуулах ажилд 3,510.71 сая, ҮТП-ийн төмөр зам барьж байгуулах ажилд 4,276.34 сая төгрөгийг "Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ"-ын хөрөнгөөр санхүүжүүлээд байна.</p> <p>Тэсрэх бодис үйлдвэрлэх хүчин чадал 15000 тн болсноор Эрдэнэт үйлдвэрийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, тэсрэх бодисоор хангах боломж бүрдэнэ. Ил уурхайн өрөмдлөг, тэсэлгээний хэсэгт эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр барих ажлыг "Монголиан Инвестмент Корпорэйшн" ХХК 2020.05.08-ны өдөр 7/006-20 дугаартай "Ил уурхайн Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг шинээр барих ажлыг түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ" байгуулж ажил эхэлсэн. 2021.09.30-ны</p>
--	--	--	--	--	--	--	--	--	---

									өдөр гэрээний хугацаа дуусаж. 2023.02.28-ыг хүртэл дахин сунгасан. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 90%-ийн гүйцэтгэлтэй байна. Барилга угсралтын ажил 85%, технологийн тоног төхөөрөмжийн угсралт 95%. Ашиглалтад оруулах хугацааг 2023 оны 07 дугаар сар хүртэл сунгах хүсэлт ирсэн.	
7				"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлын явц, хувиар		50	146,556.0	Дотоодын хөрөнгө оруулалт	Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь БНХАУ China ENFI Engineering компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр 2022.06.23-нд хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Тус ТЭЗҮ-д үндэслэсэн ЗББҮ-ийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд БНХАУ-ын Шинжан Уйгарын ӨЗО-ны Фуюун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн "Xinxin Metals" компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулахаар төлөвлөсөн Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлурги-химийн үйлдвэрээс гарах хүүхрийн давхар исэл агуулсан хийнээс элементийн хүхэр ялган авах туршилтын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тээвэрлэлт болон төсөл хэрэгжүүлэх талбайн бүтээн байгуулалтын ажлыг оновчтой зохион	50
							341,964.0	Гадаадын хөрөнгө оруулалт		

									<p>байгуулж, үйлдвэрлэлийн туршилтын ажлыг 2023 оны I улиралд багтаан бүрэн дуусгахад "China ENFI Engineering Corporation"-д дэмжлэг үзүүлэх хүсэлтийг УУХҮСайдаас БНХАУ-аас Монгол Улсад суугаа элчин сайд Цай ВэньРуй-д, Төслийн хэрэгжилт, туршилтын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийг эрчимжүүлэх асуудлаар "ЭҮ ТӨҮГ"-ын Ерөнхий захирлаас China ENFI Engineering компани болон Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайд Т.Бадрал нарт тус тус хүргүүлсэн.</p> <p>Туршилт явуулах үйлдвэрлэлийн болон иргэний барилга байгууламжийн нарийвчилсан зураг төслийн ажлууд 100%, тоног төхөөрөмжийн захиалга, худалдан авалт 100%, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 90%, үйлдвэртээ урьдчилсан угсралт хийгдсэн бөгөөд туршилтын талбай дээр хүлээж авах нөхцөл хангасны дараа нийлүүлэх боломжтой, Барилга байгууламжийн суурийн ажил 2022 оны 8 дугаар сараас хийгдэж эхэлсэн, талбайн барилгын болон угсралтын ажил 50% хийгдсэн. Орон нутагт агаарын хэм 5 хэмээс дээш дулаан байх нөхцөлд барилгын ажлыг эхлүүлэх боломжтой болох бөгөөд үйлдвэрлэлийн туршилтыг 2023.06.30-ны өдрийн дотор</p>
--	--	--	--	--	--	--	--	--	---

									<p>бүрэн дуусгахаар тохиролцсон байна.</p> <p>- ЭБМЗ-өөс ЗБХБҮ-ийн ТЭЗҮ-д өгсөн зөвлөмжийн дагуу "Аж үйлдвэрийн бүсэд мөрдөх агаарын чанарын стандартууд болон зэс хайлуулах үйлдвэрийн хаягдал утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын ялгарлын олон улсын стандартуудыг судалж үндэсний болгон боловсруулж батлуулах зөвлөх үйлчилгээ"-ний эхлэлийн тайланг 2023.01.26-ны өдөр "ЭҮ" ТӨҮГ-ийн Ажлын хэсэг хүлээж авсан.</p> <p>- ШУТИС-ын УУХ-ГУУС-ын гүйцэтгэсэн "Фосфорын ордыг ашиглах урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажил"-ын эцсийн тайланг "ЭҮ" ТӨҮГ 2022.12.21-ний өдөр хүлээн авсан.</p> <p>- ЗБХБҮ-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх ажлын тендерт шалгарсан "Хатан далай" ХХК болон ЭҮ ТӨҮГ хооронд 2023.02.08-нд ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Гэрээний хугацаа 2023.07.28-нд дуусна. Эхлэлийн тайланг ирүүлсэн ба БОАЖЯ-наас ерөнхий дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна.</p> <p>-ЗБХБҮ-ийн Техник технологийн түвшний үнэлгээ хийлгэх ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулж батлуулан тендер зарлуулахаар ХОХААБГ-т хүргүүлсэн. Тендер зарлахаар ажиллаж байна.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	---

									<p>-Хүхрийн хүчлийг ашиглан фосфорын бордоо үйлдвэрлэх туршилт судалгааг Эрдэнэт үйлдвэрийн судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн ажилтнууд гүйцэтгэж байна. Мөн "Фосфорын ордыг ашиглах урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажил"-ыг ШУТИС-ын УУХ-ГУУС-тай гэрээ байгуулан ажиллаж, эхлэлийн тайланг ЭҮ ТӨҮГ 2022.12.21-ний өдөр хүлээн авч, дундын тайлангийн танилцуулгыг 2023.05.04-ний өдөр хийсэн. Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулахад 3340.4 сая, үйлдвэрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний ажилд 118.77 сая ЗБХБҮ-ээс гарах хүхэрт хийнээс элементийн хүхэр ялган авах үйлдвэрлэлийн туршилтын ажилд 10174.1 сая нийт 13703.3 сая төгрөгийг "Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ"-ын хөрөнгөөр санхүүжүүлээд байна. Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлурги-химийн үйлдвэрийн Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлурги-химийн үйлдвэрийн үндсэн болон нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах, Фосфорын ордыг ашиглах ТЭЗҮ боловсруулах, үйлдвэрийн техник технологийн түвшний үнэлгээний ажилд нийт 29,111.64 сая төгрөг</p>
--	--	--	--	--	--	--	--	--	---

									зарцуулахаар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.	
8				"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр барих ажлын явц, хувиар	-	100	167,371.0	Дотоодын хөрөнгө оруулалт	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын захиалгаар "Майнинг Шорт Лонг Терм" ХХК-ийн боловсруулсан "Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологиор катодын зэс боловсруулах үйлдвэр"-ийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдааны 2022.06.24-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Гэвч "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын өргөтгөсөн зөвлөлийн 2022.10.13-ны өдрийн хурлаас "Гүйцэтгэгч компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын техникийн зөвлөлөөр хэлэлцэх"-ээр шийдвэрлэсэн. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Техникийн зөвлөлийн 2022.11.04-ний өдрийн хуралдаанаар тус ТЭЗҮ-ийг хэлэлцэж, Эрдэнэт үйлдвэрийн мэргэжилтнүүдийн өгсөн санал, шүүмжийн дагуу ТЭЗҮ-ийг засварлан боловсруулах, үүнд шаардлагатай хугацааг харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгах, ТЭЗҮ-ийг засварласны дараа Техникийн зөвлөлөөр дахин хэлэлцүүлж дэмжсэн тохиолдолд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу ЭҮ ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2021.11.11-ний өдрийн А-585 тушаалаар	50

									байгуулагдсан ажлын хэсэг гэрээний хугацааг 2023.03.31-ний өдөр хүртэл сунгах саналыг ХОХААБГ-т, Техникийн зөвлөлийн шийдвэрийг гүйцэтгэгч компанид тус тус албан бичгээр хүргүүлсэн. Гүйцэтгэгч компаниас 2022.01.17-ны өдөр ирүүлсэн хүсэлтийн дагуу "ЭҮ" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2022.12.09-ний өдрийн А/818 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлыг 2022.01.18-ны өдөр зохион байгуулсан бөгөөд "ТЭЗҮ-ийн засвар бүрэн хийгдээгүй байна" гэсэн дүгнэлт гарсан. Гүйцэтгэгч ТЭЗҮ-ийг засварлан 2023.02.01-ний өдөр ирүүлж ЭҮ ТӨҮГ-ын Техникийн зөвлөлийн 2023.02.08-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн тул ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хурлаар 2023.04.04-ний өдөр хэлэлцүүлж, ЭБМЗ-ийн 2023.04.04-ний өдрийн СТР/23-01-04 дугаар дүгнэлтээр дэмжигдэж, АМГТГ-ын даргын "Техник здийн засгийн үндэслэл бүртгэх тухай" 2023.04.21-ний өдрийн Т/39 дугаар тушаалаар төслийн ТЭЗҮ-ийг хүлээн аваад байна. "ЭҮ" ТӨҮГ-ын 2022.12.09-ний өдрийн А/818 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2023.04.24-ний өдрийн хурлаас 1 болон 2-р шатны ажлыг нийт ажлын 63.8% гэж үнэлж санхүүжилт
--	--	--	--	--	--	--	--	--	---

									олгохоор шийдвэрлэсэн. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын өргөтгөсөн зөвлөлийн 2022.10.13-ны хуралдааны шийдвэрийн дагуу ТЭЗҮ-ийн дараагийн шатны ажил болох "Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил"-ыг "Майнинг шорт лонг терм" ХХК-иар хийлгэх шаардлагатай эсэхийг техникийн зөвлөлийн хурал хэлэлцэж, "ЭҮ" ТӨҮГ-ын 2023.06.02-ны өдрийн А/353 тоот тушаалаар Ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, 2023.06.20-ны өдрийн дотор гэрээг дүгнэж, акт үйлдэхийг даалгасаны дагуу гэрээний явцад дүгнэлт гаргаж, акт үйлдэх ажил хийгдэж байна. SXEW үйлдвэрийн техник технологийн түвшний үнэлгээ хийлгэх ажлын техникийн тодорхойлолтыг батлуулсан.	
9	2.4.2	МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.2.1	Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх	Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмж нэвтрүүлэх ажлын явц, хувиар	7	21	587,200.0	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Уурхайн үйл ажиллагаанд шаардагдах уулын үндсэн болон туслах техник нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нийт 14 багц тендерийг зохион байгуулж 10 багцад нь буюу экскаватор, автосамосвал, бульдозер, автогрейдерүүдийг нийлүүлэгчээр "Хуа Еэ" түншлэл болон "Майнс Ап" ХХК-иуд нь шалгарсан. Эдгээрээс автосамосвал болон автогрейдерүүдийг нийлүүлэхээр 2022 онд гэрээ байгуулсан "Хуа Еэ" түншлэл нь техникүүдийг уурхайн талбайд "ЭТТ" ХК-ийн техникийн үзлэг, шалгалтаар оруулсан боловч	30

								<p>шаардлага хангаагүй тул 2023 оны 3 сарын 28-ний өдөр гэрээнээс татгалзсан талаар мэдэгдэл хүргүүлсэн. Тус техникүүдийн тендер, худалдан авалтын үйл ажиллагааг дахин зохион байгуулна.</p> <p>Майнс Ап ХХК-ийн нийлүүлэх экскаватор болон бульдозеруудыг дараах хуваарийн дагуу уурхайд хүлээн авахаар төлөвлөсөн.</p> <ul style="list-style-type: none"> • PR776 бульдозер 8 ширхэг – 2023.09-2023.12 сар • R9250 экскаватор 3 ширхэг – 2023.11-2024.03 сар • R9600 экскаватор 2 ширхэг – 2024.02 сар • R9400 экскаватор 2 ширхэг – 2024-01-2024.03 сар <p>Тус компанид 2023 оны хагас жилийн байдлаар 51.4 тэрбум төгрөгийг гэрээний дагуу олгосон.</p>	
10			Конвейерийн систем нэвтрүүлэх ажлын явц, хувиар	3	43			<p>Конвейерийн системийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, шинжээчдээс өгсөн шүүмжийн дагуу холбогдох засваруудыг 2023 оны 1 сард хийж дууссан бөгөөд 2023 оны 6 дугаар сард багтаан ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдааныг хэлэлцүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Мөн “Нүүрс баяжуулах үйлдвэрийн тэжээлийн конвейерийн системийн олон улсын шаардлагад нийцсэн зураг төсөл (FEED) боловсруулах зөвлөх үйлчилгээ” үзүүлэгчийг сонгон шалгаруулах олон улсын тендерийг 2023 оны 6 дугаар сард багтаан зарлана.</p>	30

									Одоогоор төсөлд санхүүжилт олгоогүй байна.	
11				Нүүрс ачилтын нэгдсэн төв байгуулах ажлын явц, хувиар	28	80			Тавантолгойн нүүрс ачих логикийн төвийн 2023 оны барилга угсралтын ажлыг 1 дүгээр сард эхлүүлсэн бөгөөд оны эхнээс дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд: - Багц 1. вагонд ачигчийн ажил 8%, - Багц 2. бутлуурын ажил 38%, - Багц 3. туузан дамжуурга, дагалдах тоног төхөөрөмжийн ажил 13%, - Багц 4. Овоологч тэжээгчийн ажил 3%, - Багц 5. Барилга байгууламж, зам талбай 20% - Багц 6. Эрчим хүч, автоматжуулалтын ажил 27%-ийн ажлууд тус тус нэмэлтээр хийгдэж төслийн гүйцэтгэл 67.5%-д хүрээд байна. Төслийн гүйцэтгэлийн санхүүжилтад оны эхнээс 47.3 тэрбум төгрөгийг олгосон бол төсөлд нийт 217 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоод байна.	70
12				Нүүрс баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн ажлын явц, хувиар	10	80			Тавантолгой нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах усан хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг усаар хангах "Загийн усны хоолой" гүний усны ордоос шугам, хоолой татах ажлын	70

									<p>зураг төслийг боловсруулж, Барилга хөгжлийн төвийн шинжээчдийн магадлалаар 2021 онд баталгаажуулсан. Мөн ус татах шугам хоолойн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг боловсруулах ажлыг дуусан тайланг БОАЖЯ-ны мэргэжлийн зөвлөлөөр 2022 онд баталгаажуулсан.</p> <p>Загийн усны ус татах шугам хоолойн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгч түншлэлүүдтэй гэрээ байгуулан ажлыг 2022 оны 3 дугаар сараас эхлүүлж, оны эцсээр төслийн нийт барилга угсралтын ажил 69.7%-ийн гүйцэтгэлд хүрсэн. Өвлийн улиралд барилга угсралтын ажил түр зогсож байгаад 2023 оны 4 сараас барилгын ажил эхлүүлсэн бөгөөд 2023 оны 6 сарын 10-ны байдлаар дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Гүний худгийн барилгын ажил 31%, - Ус цуглуулах 4 салбар шугамын барилга угсралтын ажил 19%, - 1500м³ багтаамжтай 2 ш усан санг доторлох, дулаалах, буцаан булах ажил зэрэг ажил 7%, - Зөөлөн ширмэн хоолой болон хуванцар хос хоолой угсрах, хийн тест хийх, буцаан булах, - Үзлэгийн худгийн хаалт арматур угсрах зэрэг ус дамжуулах гол шугам
--	--	--	--	--	--	--	--	--	--

									<p>хоолойн барилга угсралтын ажил 23%,</p> <ul style="list-style-type: none"> - Цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур босгох, угсрах ажил 6%, - Насос станцын барилгын ажил 15% тус тус хийгдэж төслийн хэмжээнд нийт ажил 89%-ийн гүйцэтгэлтэй байна. <p>2022 онд 69.7%-ийн гүйцэтгэлийг баталгаажуулж 84.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд оны эхнээс хийгдсэн ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж, санхүүжилтийг олгохоор ажиллаж байна.</p>	
13	2.4.3	МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.2.1	Стратегийн ач холбогдол бүхий Оюутолгой ордын далд уурхайн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх	Бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	78	89	2,225,850.0	Гадаадын хөрөнгө оруулалт	<p>Далд уурхайн бүтээн байгуулалтад 2023.02.01-ний байдлаар 5,504 сая ам.долларыг зарцуулсан. 2023 онд нийт 804 сая ам.доллар зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд үүнээс 1 дүгээр сард нийт 58 сая ам.долларыг зарцуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2023 онд далд уурхайн бүтээн байгуулалтыг 89 хувьд хүргэнэ гэж тусгасан. 2023 оны 1-р улиралын байдлаар Оюу толгойн далд уурхайн төслийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 86%, налуу амны барилгын ажлын гүйцэтгэл 35%, агааржуулалтын урд амны (шафт 3) босоо нэвтрэлт 413 метрт, агааржуулалтын хойд амны (шафт 4) босоо нэвтрэлт 541 метрт тус тус хүрээд байна.</p>	70

									Далд уурхайн хүдэр олборлолтын ажлыг 3-р сарын 13 нд эхлүүлсэн. Цаашдаа шат дараатайгаар налуу амны конвейерын газар доорх болон газар дээрх дэд бүтцийн барилгын ажил, агааржуулалтын босоо амнуудын нэвтрэлт, угсралт, баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн ажлуудыг хэрэгжүүлснээр үйлдвэрлэлийн хүчин чадал 2025 оны 1 улиралд хоногт 30 мянган тонн хүртэл, 2027 оны 2 улиралд хоногт 45 мянга тонн хүртэл, 2030 оны 3 дугаар улирал хоногт 95 мянга хүртэл тонн хүдэр олборлохоор төлөвлөж байна. Ингэснээр жилд 40.0 сая тн хүдэр олборлож, 1,553.0 мян.тн зэсийн баяжмал үйлдвэрлэнэ. Зэсийн баяжмал дахь зэс 436.0 мян.тн, алт 502.0 мян.унц, мөнгө 3495.0 мян.унцад хүрнэ. Экспортын орлого 26.62%-иар нэмэгдэнэ.	
14	2.4.5	МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.2.3	Геологийн зураглал, судалгааны ажлыг эрчимжүүлэн, гео мэдээллийн нэгдсэн санг баяжуулж, үйлчилгээг цахимжуулах	Геологийн 1:50000-ны масштабын зураглал бүхий газар нутгийн хэмжээ, хувиар	41.9	46	Батлагдсан: 6,630.2 Гүйцэтгэл: 2,041.6 Санхүүжилт: 1,416.6	Улсын төсөв	2023 онд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн 25 төслийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: 1. Үргэлжлэн хэрэгжих төслүүдийн 2023 оны төсөв, төлөвлөгөөг УУХУСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталж, ажлыг эхлүүлсэн. 2. Төслүүдийн 2023 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2023.02.13-аас 2023.02.17-ны	90

								<p>өдрийн хуралдаанаар хэлэлцэн зөвлөлийн дүгнэлтээр баталгаажуулсан.</p> <p>3. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй 25 төслийн 2023 оны төсөл, төсвийн тодотголыг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн гаргасан дүгнэлтэд үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023.05.19-ний өдрийн А/152-А/160, А/163, А165-А/167, А/177-А/179-А/184, А/190, А/193-А194 дүгээр тушаалаар батлуулж, судалгааны ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Үүнээс 2023 онд үр дүнгийн суурин боловсруулалтын ажилтай 13 төсөлд ҮГА-тай хамтран тайлангийн шуурхай хяналтыг хийсэн.</p> <p>4. Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн Хулд уул-50, Түдэвтэй уул-50, Дэвийн хонгор уул-50, Асгат уул-50 төслүүдийн үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар 2023 оны 4-р сарын 10, 11, 14-ний өдрүүдэд хэлэлцэж хүлээн авсан. Ингэснээр 13150,3 км2 талбай буюу 0,84 %, нийтдээ 45%-ийг хамруулсан.</p>	
15			Геологийн 1:25000-ны масштабын зураглал бүхий газар нутгийн хэмжээ, хувиар	-	0.1	-	Улсын төсөв	1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглал гүйцэтгэх, түүнд тавигдах шаадлагын төслийг боловсруулахаар ажиллаж байна.	0
16			Геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл	68	100	Батлагдсан: 456.3	Улсын төсөв	1. Монгол орны нутаг дэвсгэрийн М хавтгайн	90

				зураг хийх талбайн хэмжээ, хувиар			Гүйцэтгэл: 214.9 Санхүүжилт: 176.7		хэмжээнд Улсын геологийн 1:50000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх ажлын 2023 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар батлуулан ажлыг эхлүүлсэн. 2. Төслийн 2023 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2023.02.14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталгаажуулсан. Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын 05.19-ний өдрийн А/164 дүгээр тушаалаар батлуулан ажлыг үргэлжлүүлж байна. 3. Монгол орны нутаг дэвсгэрийн L хавтгайн хэмжээнд улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх төслийн эцсийн суурин боловсруулалтын ажилд ҮГА-тай хамтран шуурхай хяналтыг хийсэн. Монгол орны нутаг дэвсгэрийн L болон М хавтгайн (85,9%) хэмжээнд хээрийн судалгааны ажлыг бүрэн дуусгаж, эцсийн үр дүнгийн тайлан боловсруулалтын ажил хийгдэж байна.	
17				Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгаа бүхий нутаг дэвсгэрийн хэмжээ, хувиар	65	68.1	Батлагдсан: 1,788.6 Гүйцэтгэл: 45.9 Санхүүжилт: 23.5	Улсын төсөв	1. Монгол Улсын баруун, баруун өмнөд хэсгийг хамарсан 104,044.0 кв.км талбайд 1:200000-ны масштабтай агаарын геофизикийн цогцолбор судалгааны хээрийн ажлын үр дүнг боловсруулах суурин ажил болон Өмнөговь, Дорноговь аймгийн зарим сумдын нутаг дэвсгэрийг хамарсан 954.68 км.кв талбайд	70

								<p>шинээр үнэт, өнгөт металл, ГХЭ-ийн хэтийн төлөвийг тодорхойлох геофизикийн ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталсан.</p> <p>2. Шинээр хэрэгжүүлж эхлэх Хангай-1 төслийн ажлыг шилжүүлэн Ханбогдын дүүрэгт гүйцэтгэхээр геофизикийн судалгааны ажлын геологийн даалгаврыг 3-р сарын 30-ны өдөр батлан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 4-р сарын 4-нд www.tender.gov сайтаар зарласан. Хураангуй жагсаалтад орсон оролцогчид урилгыг хүргүүлж тендерийг 06.05-нд нээж үнэлгээг хийж байна.</p> <p>3. Ховд-2020 төслийн 2023 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалтай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2023.02.14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын А/168 дугаар тушаалаар баталгаажуулсан.</p> <p>4. Ховд-2020 төслийн ажлын суурин боловсруулалтын ажилд ҮГА-тай хамтран тайлангийн шуурхай хяналтыг хийсэн.</p>	
18			Геологийн зураглалыг төрөлжүүлж, шинээр болон үргэлжлүүлэн хийх судалгааны ажлын тоо	15	24	Батлагдсан: 10,154.2 Гүйцэтгэл: 2,648.1 Санхүүжилт: 1,583.1	Улсын төсөв	<p>Хотуудын гидрогеологи, геозкологийн судалгааны Дархан геозколог, Ховд геозколог, геотермийн Гүний хагарал-1, геологийн сэдэвчилсэн судалгааны Мезо-Кайнозой-2021, БМШАМ-2022, Монгол орны босоо тэнхлэгийн дагуух нутгийн үнэлгээ өгөх</p>	90

									<p>Геологийн орчин-2022 гадаад хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж байгаа МУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ-ийг хамтарсан геологийн судалгааны ажлын "Төв Ази 3D" нэртэй ажлын 5-р үе шатны төсөл болон ашигт малтмалын хэтийн төлөвийг үнэлэх ЭҮ-2-2021, ЭҮ-3-2021, ЭҮ-4-2022 ажлын төслүүдийн суурин боловсруулалтын ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар батлуулан ажлыг эхлүүлсэн.</p> <p>2. Төслүүдийн 2023 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалтай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2023.02.13-17, 03.03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн хурлын дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 05.19-ний өдрийн А/161, А/162, А/169, А/173, А/187, А/188, А/171, А/170, А/192, А/189 дүгээр тушаалаар батлуулсан. Төслүүдийн суурин болон хээрийн судалгааны ажил үргэлжлэн хийгдэж байна.</p>	
19			Мэдээллийн баяжуулалт хийж, цахимжуулах мэдээллийн сангийн тоо	бояжуулалт үйлчилгээг гео нэгдсэн	-	3	Батлагдсан: 2,075.96 Гүйцэтгэл: 851.8 Санхүүжилт: 718.9	Улсын төсөв	<p>1. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахимжуулах ажлын хүрээнд 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн Геологийн баримт-1-2022, Геологийн баримтын төв архивт цаасан байдлаар хадгалагдаж байгаа баримтыг цахимжуулах Цахим архив-1-2022, мөн архивт хадгалагдаж байгаа чулуун дээжийг бүртгэлжүүлэх Чулуун дээжийн сан-1-2022 төслүүдийн 2023 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023</p>	90

									оны А/21 дүгээр тушаалаар баталж ажлыг эхлүүлсэн. 2. Төслийн ажлын хэмжээ, арга, аргачлалтай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2023.02.16, 03.03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн УУХУСайдын 05.19-ний өдрийн А/174, А/175, А/191 дүгээр тушаалаар төсөл, төсвийн тодотголыг баталсан. Төслүүд үргэлжлэн хэрэгжиж байна.	
Бүлэг 4. Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ногоон хөгжлийн бодлого										
Зорилго 4.1. Ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглаж, хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.										
20	4.1.2	МУХТЖҮЧ-6.3.2, ЗГҮАХ-5.1.11	Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх	Онги, Хэрлэн усан цогцолбор барих төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	905,000.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх "Хөх морьт" төслийн хүрээнд Онги-Орхон усан цогцолбор нь орхон голоос Онги голын урсацыг тэтгэх замаар Улаан нуурын усны түвшинг нэмэгдүүлж говийн бүсийн экосистемийн нөхцөлийг сайжруулах зорилготой бөгөөд Өмнөговь аймгаас 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт авч төслийн Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулаад байна. Мөн "Хэрлэн-Тоонот" усан цогцолбор нь Хэрлэн голын үерийн усыг хуримтлуулж хиймэл нуур үүсгэн олон жилийн дундаж урсцын 5-9 хувийг далд хоолойгоор дамжуулан Зүүн өмнөд говийн бүсийн хүн ам, уул уурхай, газар тариалан, мал аж ахуйн усны хэрэгцээг бүрэн хангах бөгөөд Оюу-Толгой ХХК-иас 3 сая.долларын хөрөнгө оруулалт авч ТЭЗҮ, БОННУ	50

									холбогдох бичиг баримтуудыг боловсруулахаа тендер зарлаад байна.	
21	4.1.3	МУХТЖҮЧ-6.2.4, ЗГҮАХ-5.1.8	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх	Нөхөн сэргээх талбайн хэмжээ, мянган га	-	2	40,000.0	Дотоодын хөрөнгө оруулалт	2023 оны уул уурхайн компаниудын ашиглалтын үйл ажиллагааны баталгаажсан төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийг 1322.6 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 1227 га талбайд, дүйцүүлэх хамгаалах ажлыг 104337.6 га талбайд нөхөн сэргээлт хийхээр, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 онд 1362.1 га талбайд 6.3 сая мод тарихаар төлөвлөсөн байна. Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6.3 дахь заалтын дагуу 2022 оны ашиглалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланг 2023 оны 2 дугаар сард ирүүлдэг. Одоогийн байдлаар ашиглалтын үйл ажиллагааны баталгаажсан 33 тайлангаар техникийн нөхөн сэргээлтийг 156.4 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 148.4 га талбайд, дүйцүүлэх хамгаалах ажлыг 145.8 га талбайд хийсэн байна. Мөн "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 466 га талбайд 452,617 ширхэг мод тарьсан байна.	70
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН										

2023.06.15